

## Анатомийн эмгэг судлаач эмчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтын жишиг сорил

### Жишиг сорил-1

1. Нэг сонголттой тест ( Зөвхөн 1 хариулт зөв байх ) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
2. Олон сонголттой тест ( Хэдэн ч хариулт зөв байж болох )
  - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (А.)
  - 1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (В.)
  - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (С.)
  - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
  - Бүх хариулт зөв бол (E.)
3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
  - Зөв, Зөв, Зөв (А.)
  - Зөв, Зөв, Буруу (В.)
  - Зөв, Буруу, Буруу (С.)
  - Буруу, Зөв, Буруу (D.)
  - Буруу, Буруу, Буруу (E.)

### Сонгогдсон сорил

- /1./ Цочмог мухар олгойн эвдрэлтэт үрэвслийн хүндрэл нь
  1. Мухар олгой улайж хавагнах
  2. Мухар олгой илжрэх
  3. Мухар олгой наалдах
  4. Мухар олгойд буглаа үүсэх
  5. Мухар олгой чулуужих
- /2./ Дурьдсан ямар шинж тэмдэгүүд сахуулайт үрэвсэлд хамаарах вэ?
  1. Бортгон хучуур эдтэй салстад үүснэ
  2. Гүн бус үхжилтэй
  3. Ширхэглүүр өнгөр нь хөвсгөр, хялбар ховхроно
  4. Амны хөндийд салстад үүснэ
  5. Салстын эсийн хэт үржил явагдах
- /3./ Аймгийн Нэгдсэн Эмнэлэгийн Сүрьеэгийн тасагт уушгины сорвит агуйт хэлбэрийн сүрьеэ өвчтэй, уушгин зүрхний хам шинж оноштой эмчлэгдэж байсан эмчлүүлэгч мухар олгойн цочмог үрэвслийн хүндрэл хэвлийн гялтангийн идээт үрэвслээр нас баржээ. Үндсэн өвчнийг нэрлэ.
  1. Сорвит агуйт сүрьеэ
  2. Мухар олгойн цочмог үрэвсэл
  3. Уушгин зүрхний хам шинж
  4. Хэвлийн гялтангийн идээт үрэвсэл
  5. Амьсгал зүрх судасны дутагдал
- /4./ 2 ба түүнээс дээш үндсэн өвчний хэлбэрүүдийг нэрлэ?
  1. Хавсарсан өвчин
  2. Өрсөлдсөн өвчин
  3. Суурь өвчин
  4. Ятроген өвчин
  5. Дагалдах өвчин
- /5./ ЭМ-ийн сайдын А/55-р тушаалд эмнэлэгт нас барагчийн цогцост эмгэг судлалын шинжилгээг заавал хийнэ. Үүнд:
  1. Үндсэн өвчин, хүндрэл , үхлийн шалтгаан тогтоогдоогүй
  2. Цус сэлбэлттэй холбоотой бүх тохиолдолд

3. Эрүүл мэндийн байгууллагад 24 цаг хүртэлх хугацаанд эмчлүүлж байгаад нас барсан тохиолдолд

4. Эрүүл мэндийн байгууллагад эмчлүүлж байгаад гэнэт нас барсан тохиолдолд

5. Эмнэлзүйн эмч нар төгсгөлийн оношийг нийлмэл үндсэн өвчний хэлбэрээр тавьсан тохиолдолд

/6./ Доорхи эсүүдээс архаг үрэвслийн эсд хамаарахыг сонгоно уу?

1. Макрофаг
2. лимфоцит
3. Сийвэнт эс
4. Нейтрофил
5. Хөөмөг эс

/7./ Үрэвслийн үржил -пролиферац гэдэг ойлголтод ямар өөрчлөлт хамаарах вэ?

1. Нейтрофиль эс нэвчих
2. Фибробласт олшрох
3. Цусны улаан эсүүд нэмэгдэх
4. Сийвэнт ба аврага эс олшрох
5. Эдэд уураг хуримтлах

/8./ ЭМ-ийн сайдын A/55-р тушаалд нас барагчийн зхлийн шалтгаан болон өвчний онош зөв тогтоосон эсэхийг тодорхойлох эмгэг судлалын шинжилгээ хийхгүй байх тохиолдолыг нэрлэнэ үү?

1. Зоонозын халдварт (тарваган тахал, боом) өвчний тохиолдолд
2. Онош нь бүрэн батлагдсан олон эмийн дасалтай сүрьеэ өвчний тохиолдолд
3. ХДХВ-ийн халдвар батлагдсан, уг өвчнөөр нас барсан тохиолдол
4. Гадны хүч хэрэглсэн сэжигтэй нас барсан цогцост
5. Эмнэлзүйн онош нь MRI, CT-гээр батлагдсан тархины цус харвалтаар нас барсан тохиолдолд

/9./ Холестазийн морфологи шинжүүд

1. Арьсны xanthoma
2. Цөс залгисан куферийн эсүүд олширох
3. Цөсний цоргын эсүүд үржинэ
4. Цөсөн нуур үүснэ
5. Цөсний цорго тойрсон үрэвсэл илэрнэ

/10./ Н.Pylori-н гаралтай архаг шархлааны бичил бүтцийн өөрчлөлтийг нэрлэ

1. Салстын гүнд нэвтрэх
2. Нейтрофилийн урвалыг өдөөх
3. Эсийг шууд үхүүлэх
4. Уреаза ба аммони ялгаруулах
5. Салсыг хайлуулах

/11./ Төрөлхийн элэгний хатуурлын хэлбэрүүдийг нэрлэнэ үү?

1. Уилсоны хатуурал
2. Анхдагч гемахроматозийн хатуурал
3. Галактоземийн хатуурал
4. Гликоген хуримтлалын хатуурал
5. Антитрипсиний дутмагшилийн хатуурал

/12./ Салаагүй ихрийн гажгуудыг яаж нэрлэх вэ?

1. Акраниопагус-цээжээрээ нийлсэн
2. Ишиопагус-ташаагаараа нийлсэн
3. Fetus in futu-гэдсээрээ нийлсэн
4. Торакопагус-цээжээрээ нийлсэн
5. Ишиокраниопагус-цээж гэдсээрээ нийлсэн

/13./ Архаг вируст гепатитын үеийн бичил бүтцийн өөрчлөлтийг сонгон уу?

1. Олон бөөмт гепатоцит олширох
2. Куферийн эсүүд олширох
3. Гүүрэн үхжил
4. Бүгээн шилэн зураглал

5. Цөс зогсонгишил

/14./ Элэгний хатуурлын үр дүнд ямар өөрчлөлт гарах вэ?

1. Хаалган даралт ихдэх
2. Асцит үүсэх
3. Элэгний эсийн дутмагшил
4. Төмсөгний хатингаршил
5. Цусны бүлэгнэлт ихсэх

/15./ Пепсиний архаг шархлааны бүтэц зүйг нэрлэнэ үү?

1. Бага махианд элбэг
2. Гарах хэсэгт ойр
3. Ганц ширхэг байх
4. Зууван дугариг хэлбэртэй
5. 1-3см голчтой

/16./ Үүсэлгүй ургуудын жишээг нэрлэнэ үү?

1. Корпус колласиум байхгүй
2. Сертолийн эсүүд үгүй
3. Өрөөсөн бөөр үгүй
4. Улаан хоолой битүү
5. Бөөрний поликистоз

**Олон сонголттой тест ( Хэдэн ч хариулт зөв байж болох )**

**1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)**

**1 ба, 3 дугаар хариултууд зөв бол (B.)**

**2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)**

**Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)**

**Бүх хариулт зөв бол (E.)**

/17./ Дараах нэршлийг хооронд нь харгалзуулна уу?

1. Метаплази
  2. Дисплази
  3. Неоплази
  4. Атипизм (atypia)
  5. Проплази
- A. Боловсорч хөгжсөн нэг эсийн төрөл өөр төрлөөр солигдох  
B. Давхар хавтгай хучуур эд дан бортогон эсээр солигдох  
C. Хавдар  
D. Эсийн гаж хувирал  
E. Хэв шинжгүйдэл
- A. 1d, 2a, 3c, 4e, 5b  
B. 1e, 2d, 3a, 4c, 5b  
C. 1c, 2d, 3a, 4e, 5b  
D. 1a, 2d, 3c, 4e, 5b  
E. 1b, 2c, 3d, 4e, 5a

**Олон сонголттой тест ( Хэдэн ч хариулт зөв байж болох )**

**1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)**

**1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (B.)**

**2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)**

**Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)**

**Бүх хариулт зөв бол (E.)**

/18./ Висцерал ба париетал соривжилтод аль нь хамаарах вэ?

1. Мөхлөгөнцөрт эд ургах
2. Холбох эдээр солигдох

3. Хальснууд хоорондоо наалдах
  4. Ширхэглүүрийн шимэгдэл удааширах
  5. Цочмог ширхэглүүрт үрэвсэл
- /19./ Хорионэпителиома хавдрын онцлог шинжийг нэрлэнэ үү?
1. Инвазив цулцан хурааны дараа үүсч болно
  2. Хавдар нь цус харвалт үхжил ихтэй
  3. Хавдар нь цоохор зураглалтай
  4. Цитотрофобласт, синцитотрофобласт эсийн гажигшилтай
  5. Хорионы гонадотропин ихсэхгүй
- /20./ Тархины үхжлийн дараах үйлийн алдагдал үхжсэн эдийн хэмжээнээс их байхын шалтгаан юу вэ?
1. Үхжлийн голомтын хэмжээнээс
  2. Үхжлийг тойрсон үрэвслийн урвалаас
  3. Үхжлийн голомтод дахь цус харвалт
  4. Үхжлийг тойрсон эдийн хавангаас
  5. Үхжлийн дараах сорвижлоос
- /21./ Хэт үржилт артериолосклерозын онцлогуудаас заана уу?
1. Төвлөрсөн хальслаг зузаарал
  2. Суурийн мембраны хуваагдал
  3. Гөлгөр булчингийн эсийн үржил
  4. Фибрин тунадасжил
  5. Тод ягаан хиалин хуримтлал
- /22./ Цочмогдуу бактерийн эндокардитын онцлогийг заана уу?
1. Аажим эхлэлтэй
  2. Урьд нь өвчилж хатуурсан хавхлагад тохиолдоно
  3. Хоруу багатай нянгаар үүсгэгдэнэ
  4. Хавхлаган дээр ургалт жижиг
  5. Хүндрэл бага өгнө
- /23./ Хиалин артериолосклероз ямар өвчний илрэл вэ?
1. Атеросклероз
  2. Хоргүй даралт ихдэл
  3. Хорт даралт ихдэл
  4. Чихэрт шижингийн ангиопати
  5. Мембранжилт нефропати
- /24./ Баруунаас зүүн рүү чиглэх төрөлх гажгийн үндсэн шинж тэмдгүүд юу вэ?
1. Цианоз
  2. Парадоксал эмболи
  3. Хайпертрофик остеоартроз
  4. Уушгины хэт ачаалал
  5. Уушгины судасны дунд давхрагын зузаарал
- /25./ Умайн их биеийн лейомиома-ын байршлыг нэрлэ
1. Салстын доорхи
  2. Булчин дотор
  3. Сероз доорх
  4. Үтрээн доторх
  5. Умайн хүзүүний
- /26./ Олон голомтот плазмоцитома өвчнөөр ямар яс давамгайлж гэмтэх вэ?
1. Багана нуруу
  2. Гавал
  3. Хавирга
  4. Сүүж
  5. Сарвуу
- /27./ Титэм артерийн битүүрлээс гарах ишеми өөрчлөлтүүдийг заана уу?
1. Булчингийн агшилт зогсохоос өмнө эс үхлийн морфологи өөрчлөлт гарна
  2. Булчингийн эсийн дисфункци

3. Ишеми болсон газарт лейкоцит нэвчинэ
  4. Булчингийн үхлийн 1 цаг дотор эс доторх хаван үүснэ
  5. Үхжилтэй хамт фибробласт үржиж эхлэнэ
- /28./ Бүлэгнэх үхжилд хамаарахыг сонгоно уу?
1. Фибриноид үхжил
  2. Тавт үхжил
  3. Шигдээс
  4. Ээдэмцэрт үхжил
  5. Тасархайтал
- /29./ Зангилаат полиартеритийн морфологийг заана уу?
1. Судасны нүх тромбожино
  2. Фибриноид некроз үүснэ
  3. Тод дугариг хүрээтэй байна
  4. Нейтрофилийн нэвчдэс их
  5. Сүүлдээ судас сорвижин хатуурна
- /30./ Зүүнээс баруунруу чиглэх төрөлх гажгуудыг заана уу?
1. Тосгуурын таславчийн цоорхой
  2. Ховдлын таславчийн цоорхой
  3. Хаагдаагүй ductus arteriosus
  4. Том судаснуудын баруун байрлал
  5. Фаллогийн дөрвөл
- /31./ Цочмог пиелонефритийн давшилтат өөрчлөлтийн байршлыг заана уу?
1. Холтослог давхрын буглаа
  2. Тархилаг давхрын идээт голомт
  3. Хөхөнцрийн үхжил
  4. Бөөрний завсрын эдийн сорвижил
  5. Сувганцрын хөндийд өтгөн уураг хуримтлах
- /32./ Цочмог бактерийн эндокардитын морфологи онцлогийг заана уу?
1. Хоруу ихт бактери
  2. Урьд гэмтээгүй хавхлага
  3. Ургалтаас тасарч халдварт эмболи үүснэ
  4. Дархлааны суурь дээр өрнөнө
  5. Хорт хавдартай хамтарна
- /33./ Уушги авчилын ангиллыг заана уу?
1. Сорогдлын
  2. Дарагдлын
  3. Хатуурлын
  4. Бичил
  5. Шимэгдлийн
- /34./ Титэм судасны ямар өөрчлөлт шууд бөглөрөлтөд хүргэх вэ?
1. Титэм судасны спазм
  2. Товрууны цочмог өөрчлөлт
  3. 50%-70% -ийн нүхний нарийсал
  4. Титмийн тромбоз
  5. Цусны фибриноген ихсэл
- /35./ Хэрх чичрэг хавхлагын цочмог үеийн морфологийг заана уу?
1. Ашоффын бие
  2. Үүт валвулит
  3. Үрэвслийн намжилт, эдгэрэл
  4. Үүт үрэвсэл дахих
  5. Хавхлага эвдрэх
- /36./ Вегенер гранулематоз өвчний морфологи онцлогууд юу вэ?
1. Мөхлөгөнцөрт васкулит
  2. Үхжилт гранулома
  3. Бөөрний түүдгэнцэрийн голомтлог сегментэд үхжил

4. Харшлын мөхлөгөнцөр
5. Эозинофильт кардиомиопати

/37./ В12 аминдэм үгүйрлийн цус багасалын чөмөгний морфологи шинжүүдийг заана уу?

1. Ясны чөмөгт мегалобласт, эритроцит ихсэх
2. Нейтрофилийн сегмент олшрох
3. Мегакариоцитууд бөөм олон дэлбэнт
4. Метамиелоцит олширох
5. Аврага миелоцит үүсэх

**Олон сонголттой тест ( Хэдэн ч хариулт зөв байж болох )**

- 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)
- 1 ба, 3 дугаар хариултууд зөв бол (B.)
- 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)
- Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
- Бүх хариулт зөв бол (E.)

/38./ Доорх нэршлүүдийг хооронд нь уялдуулна уу?

1. Спазм
  2. Оссификаци
  3. Инкапсуляци
  4. Организаци
  5. Петрификаци
- a. Бүрхүүл хальс үүсэх
  - b. Мөхлөгөнцөрт холбогч эд ургах
  - c. Судасны агшил
  - d. Ясны ялтас ургах
  - e. Кальцийн давс тунаж шохойжих
- A. 1d, 2b, 3c, 4e, 5a
  - B. 1c, 2d, 3a, 4b, 5e
  - C. 1e, 2d, 3a, 4b, 5c
  - D. 1c, 2e, 3b, 4b, 5a
  - E. 1b, 2d, 3a, 4c, 5e

/39./ Гаж байрлалтай бөөрийг нэрлэнэ үү?

- A. Тах хэлбэрийн бөөр
- B. Өрөөсөн бөөр
- C. Аарцгийн бөөр
- D. S хэлбэрийн бөөр
- E. Уйланхайт бөөр

/40./ Зүрхний шок үүсгэгч эмгэгийг заана уу?

- A. Зүрхний хэт томрол
- B. Зүрхний өөхлөлт
- C. Зүрхний шигдээс
- D. Зүрхний хатуурал
- E. Зүрхний митрал хавхлагын нарийсал

/41./ Аль өвчний үед секвестр үүсэх вэ?

- A. Реногийн өвчин
- B. Тархины шигдээс
- C. Гар хөлөө хөлдөөх
- D. Гэдэсний хижиг өвчин
- E. Остеомиелит

/42./ Морфогенезийн алдаануудыг зөв ухагдахуунтай нь холбоно уу?

1. Agenesis
2. Aplasia
3. Hypoplasia
4. Ectopia

5. Atresia

A. Үүсэлгүйтэл

B. Дутуу хөгжил

C. Битүүрэл

D. Хөгжилгүйтэл

E. Гадна байрлал

A. 1A, 2B, 3C, 4D, 5E

B. 1B, 2D, 3E, 4A, 5C

C. 1B, 2A, 3D, 4E, 5C

D. 1D, 2A, 3B, 4E, 5C

E. 1A, 2D, 3B, 4E, 5C

/43./ Ургийн архины хам шинжийн онцлогийг дурьдана уу?

A. Архичин эхээс төрсөн хүүхэд бүрт илрэнэ

B. Заавал ураг бүрийг хамрахгүй

C. Толгой нь том байна

D. Үе мөч нь урт байна

E. Зүрхний төрөлх гажиг элбэг тохиолдоно

/44./ Атеросклерозын эхэн шатанд судасны дотор давхарт гарах гол нэг өөрчлөлтийг нэрлэнэ үү?

A. Өөхөн хуримтлал

B. Уян ширхэгийн тасрал

C. Кальцийн хуримтлал

D. Судасны нүхний нарийсал

E. Тромб үүсэл

/45./ HBV шалтгаант гепатитын үед ямар онцлог харагдах вэ?

A. Бүгээн шилэн зураглал

B. Маллорын бие

C. Гүүрэн үхжил

D. Хуурамч хэлтэнцэр

E. Өөхөн хувирал

/46./ Аалзан хальсан доорхи цус харвалтын суурь өөрчлөлтийг сонгоно уу?

A. Тархины судасны атеросклероз

B. Шарко-Бучардын цүлхэн.

C. Артерийн хананы хөгжлийн дутмагшил

D. Артерийн хананы гэмтэл

E. Артерийн хананы соривжил.

/47./ Акромегали гэдэг нь

A. Салслаг эдийн хуримтлал

B. Аргийн булчин ихсэн томрох

C. Өөх ихсэж таргалах

D. Эрхтний зах үзүүр хэсэг томрох

E. Араг ясны ургалт багасах

/48./ Тархины шигдээс –ийн үед ямар онцлогтой үхжил үүсэх вэ?

A. Коагуляци

B. Колликваци

C. Липогранулема

D. Гангрена

E. Казеоз

/49./ Доорхи нэршлийг хооронд нь уялдуулна уу?

1. Салстах үрэвсэл

2. Шар уст үрэвсэл

3. Ширхэглүүрт үрэвсэл

4. Буглаа

5. Мөхлөгөнцөрт үрэвсэл

A. Fibrinous

- B. Katarrhio
- C. Abscess
- D. Serous
- E. Granulomatousis
  - A. 1b, 2d, 3a, 4c, 5e
  - B. 1b, 2d, 3e, 4c, 5a
  - C. 1d, 2b, 3e, 4c, 5a
  - D. 1d, 2b, 3a, 4c, 5e
  - E. 1e, 2d, 3c, 4b, 5a

/50./ Дараах нэршлийг хооронд нь харгалзуулна уу?

1. Органоид
2. Гомотипик
3. Гетеротипик
4. Гистоид
5. Анаплази
  - a. Ялгарал бүрэн алдагдах
  - b. Цуллаг хэсэг давамгайлсан, ялгарал муутай хавдрын бүтэц
  - c. Цуллаг болон суурь эдээс тогтсон, тухайн эрхтэнг санагдуулахуйц хавдрын бүтэц
  - d. Анх үүссэн эдийнхээ бүтцээс ялгаатай хавдрын өөр эсийн бүтэц
  - e. Хавдрын бүтэц нь үүсэж хөгжсөн эд, эрхтэнийхээ бүтэцтэй тохирох
    - A. 1e, 2a, 3c, 4b, 5d
    - B. 1d, 2c, 3b, 4a, 5e
    - C. 1c, 2b, 3a, 4e, 5d
    - D. 1e, 2a, 3b, 4c, 5d
    - E. 1c, 2e, 3d, 4b, 5a

/51./ Хуурамч томролын үед гарах өөрчлөлтийг дурьдана уу?

- A. Эрхтний цуллаг хэсгийн эсүүд томрох
- B. Эдийн цуллаг хэсэг нь багасаж завсрын эд ихсэх
- C. Эсийн үржил хэт их явагдах
- D. Эдийн цуллаг хэсэг нь хэт ихсэх
- E. Завсар эд багасах

/52./ Зүрхний бор хатингаршилын үед ямар нөсөө үүсэх вэ?

- A. Меланин
- B. Липохром
- C. Липофусцин
- D. Гемосидерин
- E. Гематин

/53./ Зүрхний шигдээсийн үед эсийн түвшинд гарах өөрчлөлтийг тохирох хугацаатай нь уялдуулна уу?

1. 1-2 цаг
  2. 4-12 цаг
  3. 12-24 цаг
  4. 3-7 өдөр
  5. 10-14 өдөр
- A. Кардиомиоцит эсүүд бүлэгнэх үхжилт орно
  - B. Кардиомиоцит эсийн сарколеммын урагдал
  - C. Мөхлөгөнцөрт эдүүд үүсч, коллаген хуримтлагдана
  - D. Бөөм үрчийж, бутран үрэвслийн эсүүд нэвчсэн
  - E. Үхсэн эсүүдийг макрофаг залгих процесс идэвхжинэ
- A. 1A, 2B, 3C, 4D, 5E
  - B. 1B, 2D, 3E, 4A, 5C
  - C. 1B, 2A, 3D, 4E, 5C
  - D. 1D, 2A, 3B, 4E, 5C
  - E. 1A, 2D, 3B, 4E, 5C

/54./ 63 настай эрэгтэй, ар нуруугаар өвддөг. 3 удаа уушгины хатгаа туссан. Лабораторит глобулин 9.6гр/дл. Бөөр том. Глюкозури, хематури байхгүй. Бөөрний биопсид бөөрний түүдгэнцэр, судасныхаа завсар эд болон сувганцарын хананд нэг төрлийн, цул ягаан бодис хуримталсан байв. Дараах өвчнүүдийн алинтай нь тохирох вэ?

- A. Эмийн нефропати
- B. Чихрийн шижин
- C. Мембранжилт гломерулонефрит
- D. Түгмэл миелома
- E. Тогтолцооны улайх яршил

/55./ Хоргүй хавдар ихэнхдээ ямар төрлийн ургалттай байдаг вэ?

- A. Эндофит ургалт
- B. Нэвчих ургалт
- C. Экзофит ургалт
- D. Түрэг ургалт
- E. Түлхэх ургалт

/56./ Дасан зохицлын үед эд эрхтний эсийн тоо үржиж олшрохыг юу гэж нэрлэх вэ?

- A. Meteplasia
- B. Proplasia
- C. Hyperplasia
- D. Neoplasia
- E. Dysplasia

/57./ Дараах нөхцлүүдийн алинд нь байран хемосидероз үүсэх вэ?

- A. Судасны гадна цус задарснаас үүснэ
- B. Судсан дотор цус задарснаас үүснэ
- C. Билирубин хуримтлагдсанаас үүснэ
- D. Цус их хэмжээгээр задарснаас үүснэ
- E. Элэгдлийн нөсөөнөөс үүснэ

/58./ Судасны хананд өөх шингээгч ямар төрлийн эс байх вэ?

- A. Фибробласт эс
- B. Эндотелийн эс
- C. Мэдрэлийн эс
- D. Эпителийн эс
- E. Гөлгөр булчингийн эс

/59./ Зүрхний зүүн титэм судасны тойрох салаа бөглөрөх үеийн шигдээсийн байршлыг заана уу?

- A. Зүүн ховдлын ар хана
- B. Зүүн ховдлын хажуу хана
- C. Таславчийн ар хэсэг
- D. Баруун ховдлын өмнөд хана
- E. Зүрхний орой хэсэг

/60./ Сувганцарын цочмог үхжлийн бичил эсүүд аль нь вэ?

- A. Сувганцарын үхжилт
- B. Тубулорексис
- C. Венийн цус дүүрэлт
- D. Сувганцарын усархаг ба венийн хувирал
- E. Лимфийн зогсонгишил

/61./ Архаг гломерулонефритийн бичил өөрчлөлт аль нь вэ?

- A. Артериолын битүүрэл
- B. Түүдгэнцэрийн сорвижил
- C. Түүдгэнцэрийн томрол
- D. Бөөрний артериолын фибриноид үхжил
- E. Түүдгэнцэрийн капиллярын зузаарал

/62./ Хорт шархлааны аль хэсгээс амьд сорьц (биопси) авах вэ?

- A. Ёроолоос
- B. Дунд хэсгээс

- C. Хажуугийн эрүүл эдээс
- D. Үхэжсэн эдээс
- E. Ирмэг хэсгээс

/63./ Дараах нэршлийг хооронд нь харгалзуулна уу?

- 1. Аденома
- 2. Карцинома
- 3. Папиллома
- 4. Саркома
- 5. Хондрома
- A. Булчирхайлаг хучуур эдийн хоргүй хавдар
- B. Бүрхүүл хучуур эдийн хоргүй хавдар
- C. Бүрхүүл хучуур эдийн хортой хавдар
- D. Мезенхимийн хавдар
- E. Мөгөөрсний эдийн хавдар
- A. 1c, 2a, 3b, 4e, 5d
- B. 1a, 2c, 3b, 4d, 5e
- C. 1d, 2c, 3b, 4d, 5a
- D. 1b, 2e, 3c, 4d, 5e
- E. 1c, 2e, 3b, 4a, 5d

/64./ Архаг простатитын үед бичил өөрчлөлтийг нэрлэнэ үү?

- A. Үрэвслийн мононулеарь эс давамгайлна
- B. Лимфофолликуляр харагдана
- C. Плазмоцит давамгайлна
- D. Архаг үрэвслийн эсүүд булчирхайд давамгайлна
- E. Метаплази өөрчлөлт илэрнэ

/65./ Эсийн дотор хөөмөгшил үүсэх нь ямар механизмаас хамаарах вэ?

- A. Эсийн дотор K<sup>+</sup> ихсэл
- B. Проетеаза ферментийн идэвхижил
- C. Эсийн доторх Na<sup>+</sup> ихсэл
- D. Эсийн доторх Ca<sup>+</sup> ихсэл
- E. Бөөмийн хроматины хэсэгрэл

/66./ 7 настай хөвгүүний арьсанд тууралт гарч эдгэрч байв. Үзэхэд хацар дээр нь шаргалдуу тав үүсч ховхорч байв. Түүнээс ургуулж үзэхэд А бүлгийн стрептококк илрэв. Антибиотик эмчилгээ хийв. Нэг долоо хоногийн дараа халуурч бараавтар шээс гарав. Лабораторид антистрептолизин О титр 1:1024 гарчээ. Энэ байдлын төгсгөл юу байх бол?

- A. Зүрхний ревматизмаар хүндэрнэ
- B. Бөөрний архаг дутмагшилд хүргэнэ
- C. Шээсний замын халдвар болно
- D. Эмчилгээгүйгээр бүрэн эдгэрнэ
- E. Хавирган сарт гломерулонефритэд шилжинэ.

/67./ Тархины шигдээс үүсснээс хойш 1-2 долоо хоногийн дараа гарах өөрчлөлтийг нэрлэнэ үү?

- A. Үхжил, нейтрофиль эсийн нэвчдэс
- B. Макрофаг эсүүд болон эрт үеийн глиоз
- C. Урвалж глиоз болон судасны олшрол
- D. Глиал сорви
- E. Улаан нейрон

/68./ 28 настай, дуучин залуу. Шөнийн клубт дуулдаг. Сүүлийн үед хоолой сөөн, дуу нь бүдгэрч бүдүүрэх болжээ. Үзэхэд халуунгүй, хүзүүний ард тэмтрэгдэх зүйлгүй. Ханиахад цэр гарахгүй. Тамхи татдаг. Дараах эмгэгүүдээс аль нь байж болох вэ?

- A. Сахуулайт хальс
- B. Давхраат эсийн папиллома
- C. Дууны хөвчийн үрэвсэл
- D. Урвалт зангилаа
- E. Давхраат эст өмөн

/69./ Chediak Higashi –ийн хам шинжийн үед аль нь илрэх вэ?

- A. Сперм хөдлөх чадваргүй болсны улмаас үргүйдэл үүснэ
- B. Амьсгалын замын салст бүрхүүлийн эсүүдийн сормуусны намирах хөдөлгөөн алдагдах
- C. Элэгний эсийн дотор завсрын филамент хуримтлагдснаас маллорын биенцэр үүсэх шинж илэрнэ
- D. Гөлгөр эндоплазмын торны хоргүйжүүлэх үйл ажиллагаа алдагдана
- E. Залгигч эсүүдийн фаголизосом үүсэх үйл ажиллагаа алдагдаж улмаар эсийн дархлаа дутал үүснэ.

/70./ Хөдөлгөөний мэдрэл тасрахад ямар эд хатингарших вэ?

- A. Зүрхний булчин
- B. Ходоод гэдэсний гөлгөр булчин
- C. Араг ясны булчин
- D. Цусны судас
- E. Лимфийн судас

/71./ Хорт шархлаа нь хавдрын үед тохиолдоно, яагаад гэвэл хорт хавдрын үхжсэн эд ховхрон унаснаас шархлаа үүснэ.

/72./ Бөөрний сувганцрын үхжлийн дараа түүний нөхөн төлжилт сайн явагддаг. УЧИР НЬ суурийн мембран тасарсан нөхцөлд эсүүд төлжиж чадахгүй болно.

/73./ Хэт үржил (гипеплази) нь эд, эсийн гажигшил агуулна УЧИР НЬ хавдрын чанартай ургалт юм.

/74./ Папиллома нь ихэвчлэн хөхлөгт бүтэцтэй, УЧИР НЬ ямагт хучуур эдийн гадаргуугаас ургана.

/75./ Цусан хатгааны саарал элэгшлийн үед уушги агааргүй, хатуу, хүнд болно, УЧИР НЬ амьсгуурсын хөндий шүүдсээр бөглөрнө.

**Олон сонголттой тест ( Хэдэн ч хариулт зөв байж болох )**

- 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)**
- 1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (B.)**
- 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)**
- Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)**
- Бүх хариулт зөв бол (E.)**

/76./ Халдварт өвчний голомт гэж юуг хэлэх вэ?

- A. Халдварын эх уурхай оршиж буй газар нутаг
- B. Халдварт өвчтэй хүн байгаа газар
- C. Эпидемийн процессын 3 хэлхээ бүрдсэн газар нутаг
- D. Халдвар хадгалагч, өвчтөн байгаа газар
- E. Бохирдсон хоол, хүнс, ус

/77./ Эрүүл мэндийн судалгааны ёс зүйн зарчмуудыг албан ёсоор анх баталгаажуулсан баримт бичгийг нэрлэнэ үү?

- A. Бельмонтын тайлан
- B. Хельсинкийн деклараци
- C. ЛаЛондын тайлан
- D. Нюрембергийн код
- E. Алма-Атагийн тунхаг

/78./ Эрүүл мэндийн боловсролын одоогийн байдалд дараах нь орно

- A. зөвхөн эрүүл мэндийн харилцаа холбооны үйл ажиллагаа
- B. зөвхөн хүрээлэн буй орчны хүчин зүйлс
- C. зөвхөн эрүүл мэндийн уулзалт зөвлөгөөн

- D. зөвхөн сургуулийн эрүүл мэндийн боловсрол
- E. эрүүл мэндийг хамарсан бүх төрлийн боловсролын арга

/79./ Вакцинд тавигдах хамгийн гол шинж юу вэ?

- A. Антиген шинж
- B. Хоргүй
- C. Дархлаа тогтоох
- D. Ариун
- E. Тогтвортой

/80./ Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих гэдэг нь \_\_\_\_\_ үйл ажиллагаа юм.

- A. Ажилчдын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах
- B. Хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах
- C. Ажлын байраар дамжуулан ажиллагсадын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих
- D. Ажлын байранд ажиллагсадын сайн сайхан байдлыг хангах, эрүүл мэндийг дэмжих
- E. Ажилтай холбоотой өвчлөлийг бууруулах

/81./ Халдвар дамжуулагч хүчин зүйлийн тодорхойлолтыг заана уу?

- A. Өвчин үүсгэгч хувьсал хөгжлийн явцдаа олж авсан өөрийнхөө биологийн зүйлийг хадгалахын тул нэг бие махбодиос нөгөөд шилжих орон зайн солилцоо
- B. Тухайн нөхцөлд өвчин үүсгэгчийг нэгээс нөгөөд зөөвөрлөхөд оролцож байгаа гадаад орчны элементүүд
- C. Өвчин үүсгэгчийг нэгээс нөгөөд дамжуулж байгаа хүн болон амьтад
- D. Өвчтэй хүн болон мал амьтад
- E. Халдварт өвчтэй хүний цус цусан бүтээгдхүүн

/82./ Халдвар дамжуулагч хүчин зүйлийн тодорхойлолтыг заана уу?

- A. Өвчин үүсгэгч хувьсал хөгжлийн явцдаа олж авсан өөрийнхөө биологийн зүйлийг хадгалахын тул нэг бие махбодиос нөгөөд шилжих орон зайн солилцоо
- B. Тухайн нөхцөлд өвчин үүсгэгчийг нэгээс нөгөөд зөөвөрлөхөд оролцож байгаа гадаад орчны элементүүд
- C. Өвчин үүсгэгчийг нэгээс нөгөөд дамжуулж байгаа хүн болон амьтад
- D. Өвчтэй хүн болон мал амьтад
- E. Халдварт өвчтэй хүний цус цусан бүтээгдхүүн

/83./ Бруцеллёз өвчний халдварын эх уурхайд чиглэсэн урьдчилан сэргийлэлтийг нэрлэнэ үү?

- A. Мэдээлэл сурталчилгаа хийх
- B. Өвчтэй мал амьтдыг эрүүл сүргээс нь тусгаарлах
- C. Төл бүрийг вакцинжуулах
- D. Лабораторийн түвшинд тандалт судалгаа явуулах
- E. Мах хэрчсний дараа гараа угаах

/84./ Нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлуудыг нэрлэнэ үү?

1. Насжилт
2. 5 хүртэлхи насны хүүхдийн эндэгдэл
3. Хөгжиж байгаа орон дах халдварт өвчнүүд
4. Осол гэмтэл
5. ДОХХ

/85./ Хог хаягдлын менежмент гэдэг ойлголтонд багтах элементүүдийг нэрлэнэ үү?

1. Хадгалах
2. Халдваргүйжүүлэх
3. Дахин ашиглах
4. Зөөвөрлөх
5. Цуглуулах

/86./ Эрүүл мэндийн тухай хуулийн зорилтод үл нийцэх ойлголт аль нь вэ?

- A. Эрүүл мэндийн даатгал, сан, олголт, зохицуулалт
- B. Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндсэн зарчмыг тодорхойлох
- C. Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэний гүйцэтгэх үүрэг

D. Иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангах

E. Эрүүл мэндийн байгууллага, ажилтны үйл ажиллагаа /87./ "Сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал" гэсэн ойлголтын тодорхойлолтыг нэрлэнэ үү

A. Нийгэм, эдийн засаг, сэтгэл зүйн шалтгааны улмаас хүний сэтгэхүй, сэтгэл хөдлөл, зан үйл түр хямарсан байдлыг

B. Улс төр, эдийн засаг, нийгмийн шалтгааны улмаас хүний сэтгэл хөдлөл, сэтгэхүй түр хямарсан байдлыг

C. Сэтгэл зүйн шалтгааны улмаас хүний сэтгэхүй, зан үйл сэтгэл хөдлөл түр хямарсан байдлыг;

D. Нийгэм, улс төр, эдийн засгийн хямралын улмаас хүний сэтгэхүй, сэтгэл хөдлөл, зан үйл хямарсан байдлыг;

E. Нийгэм, сэтгэл зүйн шалтгааны улмаас хүний сэтгэхүй, сэтгэл хөдлөл, зан үйл түр хямарсан байдлыг;

/88./ Эмийн сангийн байршил болон үйлчлэх хүрээг тохируулан тогтоох, эм, эмнэлгийн хэрэгслээр хангах үйл ажиллагааг зохицуулах үүргийг ямар байгууллага хүлээх вэ?

A. Засгийн газар

B. Засаг даргын тамгын газар

C. Нутгийн захиргааны байгууллага

D. УИХ

E. Эмийн байгууллага

/89./ "Цуврал" гэж юуг хэлэх вэ?

A. технологийн олон удаагийн шат дамжлагаар үйлдвэрлэсэн эмийн бүтээгдэхүүний багцын тоо хэмжээг

B. үйлдвэрлэлийн технологийн нэг удаагийн шат дамжлагаар үйлдвэрлэсэн эмийн бүтээгдэхүүний багцын тоо хэмжээг

C. үйлдвэрлэлийн нэг удаагийн шат дамжлагаар үйлдвэрлэсэн эмийн бүтээгдэхүүний багцыг

D. үйлдвэрлэлийн технологийн нэг удаагийн шат дамжлагаар үйлдвэрлэсэн эмийн бүтээгдэхүүний чанарыг

E. үйлдвэрлэлийн технологийн нэг удаагийн шат дамжлагаар үйлдвэрлэсэн эмийн тоо хэмжээг

/90./ Хэрэв та ёс зүйн ноцтой зөрчил гаргасан нь нотлогдвол хуулийн дагуу эмчлэх , сувилах эрхээ ямар хугацаагаар хасуулах вэ?

1. 1-3 жил

2. 5 жил хүртэл

3. 2 жил

4. 6 сараас 1 жил хүртэл

5. 1 жилээс 5 жил хүртэл

/91./ Хөндлөнгийн саадгүй орчин гэж

A. Үйлчлүүлэгчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байх үед бусад эмнэлгийн мэргэжилтэн саад болохооргүй өрөө тасалгаа

B. Үйлчлүүлэгчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байх үед хөндлөнгийн хүн саад болохооргүй зориулалтын хаалт

C. Үйлчлүүлэгчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байх үед хөндлөнгийн хүн /бусад эмнэлгийн мэргэжилтэн, үйлчлүүлэгч/ саад болохооргүй өрөө тасалгаа эсвэл зориулалтан хаалтаар тусгаарлагсан өрөө тасалгаанд тусламж үзүүлэх

D. Үйлчлүүлэгчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байх үед хөндлөнгийн үйлчлүүлэгч саад болохооргүй өрөө тасалгаа эсвэл зориулалтан хаалтаар тусгаарлагсан өрөө тасалганд тусламж үзүүлэх

E. Үйлчлүүлэгчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байх үед бусад эмнэлгийн мэргэжилтэн саад болохооргүй өрөө, хаалтаар тусгаарлагдсан өрөө тасалгаанд туслалцаа үзүүлэх

/92./ Ямар тохиолдолд эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчид эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхээс ёс зүйн хувьд татгалзах эрхтэй вэ?

- A. Өөрийн нарийн мэргэжил тохирохгүй тохиолдолд
- B. Эм ,багаж хэрэгсэл дутмаг тохиолдолд
- C. Үйлчлүүлэгч ёс бусаар харилцсан тохиолдолд
- D. Үйлчлүүлэгч согтуу байгаа тохиолдолд
- E. Эмчилгээ үйлчилгээ үзүүлэх тохиромжгүй нөхцөлд

/93./ Хэрэв та өөрийн судалгаандаа амьтан ашиглах бол ямар нэг зөвшөөрөл авах шаардлагатай юу ?

- A. Мэдэхгүй
- B. Энэ талаар олон улсын хэмжээний эрх зүйн зохицуулалт байхгүй
- C. Холбогдох ёс зүйн хорооноос зөвшөөрөл авна
- D. Хүн амьтан ялгаатай шүү дээ
- E. Энэ асуудлын талаар дуулаач үгүй

/94./ Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчийг сонголт хийх боломж олгохын тулд ямар хэлбэрээр зөвлөлгөө өгөх, санал болгох үүргийг ёс зүйн үүднээс хүлээх вэ?

- A. Өөрийн байгууллагын чадавхийг бодиттой үнэлсэний үндсэн дээр
- B. Хүнлэг ёсны үүднээс
- C. Цаг хугацааны хамааралаас
- D. Байгууллагын эрх ашгийн үүднээс
- E. Бусад мэргэжилтнүүдийн тусын тулд

/95./ Эмнэлгийн мэргэжилтэн тухайн хүний амьдралын төгсгөл сөрөг талруу нэгэнт тодорхой болсон тохиолдолд баримтлах ёс зүйн хандлагыг тодорхойлно уу.

- A. Оношын үнэнийг хэлэх нь буруу
- B. Өрхийн эмчид нь даалгана
- C. Өвдөлт , зовиур шаналгааг нь багасгах бололцоотой бүх арга хэмжээг авна
- D. Ар гэрийнхэнд нь асарч сувилах талаар зөвлөлгөө өгнө
- E. Эрүүл мэндийн сайн дурын итэвхтүүдийн асрамжинд шилжүүлнэ

/96./ Үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж үйлчилгээний талаар шийдвэр гаргах явцад эмч нарын хооронд санал зөрөөтэй асуудал гарвал эцсийн шийдвэрийг хэн гаргах вэ ?

- A. Эмчлэгч эмч
- B. Тасгийн эрхлэгч
- C. Зөвлөх эмч
- D. Эмнэлгийн дарга
- E. Хамгийн олон жил ажилласан туршлагатай эмч нь

/97./ Эмнэлгийн мэргэжилтэн яагаад үйлчлүүлэгчийг өөрийн нь зөвшөөрөл үгүйгээр анагаах ухааны болон шинжлэх ухааны туршилтанд оруулж болохгүй бэ?

- A. Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэхийн үүднээс
- B. Эрүүл мэндэд нь харш учраас
- C. Хуулиар хориглодог учраас
- D. Ашиг сонирхолын зөрчлийн үүднээс
- E. Шинжлэх ухааны хөгжлийн үүднээс болно

/98./ Эмнэлгийн мэргэжилтэн нь ял эдэлж буй хүнд тусламж, үйлчилгээг хэрхэн үзүүлэх вэ

- A. Шүүхий шийдвэрээс үл хамааран тусламж, үйлчилгээг тэгш чанартай үзүүлнэ
- B. Шүүхийн шийдвэрээс хамаарна, тусламж үйлчилгээг тэгш үзүүлэхгүй
- C. Тухайн нөхцөл байдлаас хамаарч тодорхой үйлчилгээг үзүүлнэ
- D. Ял эдэлж буй хүний өвчний байдлаас хамаарна
- E. Тухайн ял эдэлж буй хүний ухамсарын байдлаас хамаарна

/99./ Эмнэлгийн мэргэжилтэн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялантай харилцахдаа ёс зүйн үүднээс хэрхэн хандах вэ?

1. Доромжлохыг эсэргүүцэнэ
2. Басамжлахыг эсэргүүцэнэ
3. Тарчлаан зовоохын эсрэг байна
4. Эмнэлгийн мэргэжилтэн миний хувьд зөвхөн эмнэлгийн тусламж үзүүлнэ
5. Өлсгөлөн зарлахыг хориглоно

/100./ Иргэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахдаа ёс зүйн хүрээнд доорхи эрхүүдээс аль алиныг нь эдлэх эрхтэй вэ?

1. Өөрийн эрүүл мэндийн байдалд сөрөг эрсдэл учирсан тохиолдолд бусдын унаа, хөсгийг дайчлах
2. Хувийн мэдээллэлийн нууцаа өөрөө зөвшөөрсөн буюу хуулиар зөвшөөрөгдсөнөөс бусад тохиолдолд задрахгүй байх баталгаагаар хангагдах.,
3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлбөрийг өөрөө шийдэж төлөхгүй байх
4. Эмчилгээ, үйлчилгээний үр дүн, өвчний явц, цаашид хийх эмчилгээ, гарч болох үр дагаварын талаар эмнэлгийн мэргэжилтэнтэй ярилцах, тайлбар авах.,
5. Хувийн яаралтай асуудлаар гоц халдварын бүсээс гарах эрхтэй

### **Сорилын зөв хариулт -Жишиг сорил-1**

1-С, 2-А, 3-С, 4-В, 5-Е, 6-А, 7-С, 8-Е, 9-Е, 10-С, 11-А, 12-Е, 13-В, 14-В, 15-Е, 16-А, 17-Д, 18-А, 19-В, 20-А, 21-С, 22-А, 23-С, 24-А, 25-Е, 26-В, 27-А, 28-С, 29-А, 30-Е, 31-А, 32-А, 33-А, 34-В, 35-А, 36-А, 37-В, 38-Д, 39-С, 40-С, 41-Е, 42-Е, 43-В, 44-А, 45-А, 46-С, 47-Д, 48-В, 49-А, 50-Е, 51-В, 52-С, 53-С, 54-А, 55-Е, 56-С, 57-В, 58-Е, 59-В, 60-В, 61-В, 62-Е, 63-В, 64-А, 65-С, 66-А, 67-С, 68-В, 69-В, 70-С, 71-С, 72-А, 73-Е, 74-С, 75-С, 76-С, 77-Д, 78-Е, 79-С, 80-С, 81-В, 82-В, 83-В, 84-Е, 85-Е, 86-А, 87-Е, 88-С, 89-В, 90-Д, 91-С, 92-С, 93-С, 94-А, 95-С, 96-А, 97-А, 98-А, 99-А, 100-С,

### **Жишиг сорил-2**

1. Нэг сонголттой тест ( Зөвхөн 1 хариулт зөв байх ) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
2. Олон сонголттой тест ( Хэдэн ч хариулт зөв байж болох )
  - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (А.)
  - 1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (В.)
  - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (С.)
  - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
  - Бүх хариулт зөв бол (Е.)
3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
  - Зөв, Зөв, Зөв (А.)
  - Зөв, Зөв, Буруу (В.)
  - Зөв, Буруу, Буруу (С.)
  - Буруу, Зөв, Буруу (D.)
  - Буруу, Буруу, Буруу (Е.)

Сонгогдсон сорил

/1./ Бамбайн дэргэдэх булчирхайн дааврын үйлдэлтэй холбоотой зөв хариуг сонгоно уу?

1. Остеокластыг идэвхжүүлэх
2. Холын тахир сувганцраар кальци эргэн шимэгдэхийг ихэсгэх
3. Бөөрөнд идэвхтэй Д амин дэм үүсэхийг ихэсгэх
4. Гэдсээр кальци шимэгдэхийг ихэсгэх
5. Шээсээр кальци гадагшлахыг ихэсгэх

/2./ Кретинизм үүсгэгч шалтгааныг нэрлэнэ үү?

1. Иодын дутагдал
2. Бамбай булчирхайн төрөлхийн гажиг
3. Бамбайн дааврын нийлэгжилд оролцдог энзимийн дутагдал
4. Туяаны нөлөө
5. Шалтгаан тодорхойгүй

/3./ Вильсоны өвчний үед лабораторид ямар өөрчлөлт илэрдэг вэ?

1. Сийвэнгийн церулоплазмин ↓
  2. Хиперкуприури
  3. Шээсэнд амин хүчил, глюкоз ялгарах нь ↑
  4. Цусан дахь глюкоз ↑
  5. Сийвэнгийн трансферрин↑
- /4./ Шүүлтүүрийн хоригийн бүтцийг нэрлэнэ үү?
1. Эндотелийн эс
  2. Подоцитийн сэртэнгийн үе
  3. Суурь мембран
  4. Баумены бүрхүүл
  5. Ойрын тахир сувганцар
- /5./ Уйланхайт сорвижлын үед амьсгалын тогтолцоонд ямар өөрчлөлт ажиглагдах вэ?
1. Гуурсан хоолой салсаар бөглөрөх
  2. Хундганцар эсүүдийн хэт үржил
  3. Уушгины архаг халдвар
  4. Гуурсан хоолойн уужрал
  5. Цээж торх хэлбэртэй болох
- /6./ Карциноид хавдартай холбоотой зөв ойлголтыг сонгоно уу?
1. Булчин дотор, салст доор цул үүсгэнэ
  2. Нейроэндокрины эсүүдээс гаралтай
  3. Хавдрын эсүүд нь цэгэн зураас бүхий бөөмтэй
  4. Хавдрын эсүүд нь сийвэндээ ягаан мөхлөг агуулна
  5. Хавдрын цул нь шаравтар өнгөтэй
- /7./ Гуурсан хоолойн уужрал өвчтэй хүний цэр ямар онцлогтой вэ?
1. Их хэмжээтэй
  2. Идээтэй
  3. Хэд хэдэн үеэс тогтсон
  4. Өмхий үнэртэй
  5. Цустай
- /8./ Зүрхний булчингийн шигдээсийн шалтгааныг сонгоно уу?
1. Титэм судасны агшил
  2. Титэм судасны эмболи
  3. Титэм судасны тромб
  4. Титэм судасны дутуу хөгжил
  5. Титэм судасны хажуугийн салаанууд
- /9./ Хавдрын шалтгаант яс үений хэт томролт эмгэгийн үед ямар үенүүд ихэвчлэн өртдөг вэ?
1. Хурууны шивнүүр
  2. Алга
  3. Өлмий
  4. Шуу
  5. Бугалга
- /10./ Холимог салс шүүрүүлдэг эрхтнийг сонгоно уу?
1. Умайн хүзүү
  2. Гуурсан хоолой
  3. Үтрээ
  4. Шүлсний булчирхай
  5. Ходоод
- /11./ Опсонин бүрхүүлийн ач холбогдлыг нэрлэнэ үү?
1. Хемоаксисыг дэмжих
  2. Фагоцитозыг хөнгөвчлөх
  3. Нянг үрэвслийн голомтод барих
  4. Нянгийн хорыг саармагжуулах
  5. Нейтрофилийн апоптозыг саатуулах
- /12./ Дараах жагсаалтаас зөв ойлголтыг сонгоно уу?

1. Тухайн хавдрын ялгарал муу байх тусам ургал нь хурдан байдаг
  2. Дийлэнх хоргүй хавдар хэдэн сар жилээр аажим ургадаг
  3. Ихэнх хортой хавдар орчмын эд рүүгээ цөмөрч бүтцийг алдагдуулдаг
  4. Хортой хавдрын эсүүд алсын эрхтэнд үсэрхийлснээр нас баралтын шалтгаан болдог
  5. Зарим хавдар үхлийн улмаас устан үсэрхийлэх нь үндэс болно
- /13./ Дараах хавдрын аль нь гадаргуугийн хучуур эдээс гаралтай вэ?
1. Шар уст аденома
  2. Хөхлөгт шар уст цистаденокарцинома
  3. Салсархаг цистаденокарцинома
  4. Бреннерийн хавдар
  5. Эндометриод хавдар
- /14./ Өргөн цооног бүхий зүүгээр эдийн гүн рүү хатгаж, цооногийн хөндийд орсон урт нарийн эдийг авах аргыг нэрлэнэ үү?
- A. Пипелли биопси
  - B. Цөм биопси
  - C. Цоологч биопси
  - D. Зорох биопси
  - E. Конус биопси
- /15./ Дисплази хэмээх ойлголтыг тодорхойлно уу?
- A. Гаж үржил
  - B. Завсрын үржил
  - C. Хэт үржил
  - D. Шинэ үржил
  - E. Холимог үржил
- /16./ Хемоглобины найрлагыг тодорхойлно уу?
- A. Хемоглобин=Хем (Fe+порфирин)+глобин ( $2\alpha+2\beta$ )
  - B. Хемоглобин=Хем (Cu+порфирин)+глобин ( $2\alpha+2\beta$ )
  - C. Хемоглобин=Хем (2 порфирин)+глобин ( $4\alpha$ )
  - D. Хемоглобин=Порфирин+полипептид
  - E. Хемоглобин=Ферритин+аминхүчил
- /17./ Ямар эдэд бүлэгнэх үхжил явагддаг вэ?
- A. Шингэн багатай, уургаар баялаг
  - B. Шингэн багатай, өөхний эд ихтэй
  - C. Шингэн ихтэй, ферментийн идэвх ихтэй эдэд
  - D. Гадаад орчинтой харьцдаг эрхтэнд
  - E. Ялзруулагч нянтай холбоотойгоор хаана ч үүсэж болно
- /18./ Мезинхимээс гаралтай хортой хавдрыг хэрхэн нэрлэдэг вэ?
- A. Миксома
  - B. Мезотелиома
  - C. Тератома
  - D. Саркома
  - E. Лейкеми
- /19./ Хамгийн хортой төмсөгний хөврөл эсийн хавдрыг нэрлэнэ үү?
- A. Семинома
  - B. Үр хөврөлийн карцинома
  - C. Шар уургийн хүүдийн хавдар
  - D. Тератома
  - E. хориокарцинома
- /20./ Ямар шигдээсийн үед тампонад үүсэх аюултай вэ?
- A. Ховдол хоорондын таславчийн шигдээс
  - B. Хөхлөг булчингийн шигдээс
  - C. Трансмурал шигдээс
  - D. Эндокардийн доорх шигдээс
  - E. Бичил голомтот шигдээс

- /21./ Цэсний хүүдийн цочмог үрэвслийн үед илэрдэг Murphy-ийн шинжтэй холбоотой зөв хариуг сонгоно уу?
- A. Хоол идэхэд дотор муухайрах
  - B. Хэвлийн баруун дээд хэсгээр эмзэглэх
  - C. Хэвлийн баруун дээр хэсэгт дарахад амьсгал тасалдах
  - D. Баруун далны шонтон руу өвдөлт дамжих
  - E. Өөх тостой хоол идэхэд шингэхгүй байх
- /22./ Хамгийн хурдан явцтай ургалтын хэлбэрийг заана уу?
- A. Гадраасаа шилжих ургалт
  - B. Түлхэх ургалт
  - C. Эвдрэлт ургалт
  - D. Түрэг ургалт
  - E. Нэвчмэл ургалт
- /23./ Гол судасны цуурлыг нөхцөлдүүлдэг эмгэг өөрчлөлтийг заана уу?
- A. Атерома
  - B. Цүлхэн
  - C. Ширхэглүүр төст үхжил
  - D. Дунд бүрхүүлийн уйланхайт үхжил
  - E. Хэт мэдрэгшлийн урвал
- /24./ Лейкоцитийн судаснаас гадагшлах үйл явцыг зөв дараалуулна уу?
- A. Наалдах – гадагшлах – нүүдэллэх – өнхрөх
  - B. Өнхрөх – наалдах – захлах – нүүдэллэх
  - C. Захлах – өнхрөх – наалдах – гадагшлах – нүүдэллэх
  - D. Захлах – наалдах – гадагшлах – нүүдэллэх – захлах
  - E. Наалдах – гадагшлах – нүүдэллэх – өнхрөх – захлах
- /25./ Нүүрстөрөгчийн бус эсвэл тогтвортой хүчлийн алдагдахад биед ямар эмгэг байдал үүсдэг вэ?
- A. Бодисын солилцооны хүчилшил
  - B. Бодисын солилцооны шүлтшил
  - C. Амьсгалын хүчилшил
  - D. Амьсгалын шүлтшил
  - E. Ус-электролитийн тэнцвэргүйжил
- /26./ Үтрээний аденозыг зөв тодорхойлно уу?
- A. Хавтгай хучуур эд – Булчирхайлаг эд
  - B. Булчирхайлаг эд – Хавтгай хучуур эд
  - C. Шилжвэр хучуур эд – Булчирхайлаг эд
  - D. Булчирхайлаг эд – Булчирхайлаг хавдар
  - E. Хавтгай хучуур эдэд булчирхайлаг хорт хавдар үсэрхийлэх
- /27./ Поттын өвчний талаарх зөв ойлголтыг сонгоно уу?
- A. Тархины зөөлөн бүрхүүл микобактераар гэмтэх
  - B. Нугас микобактераар гэмтэх
  - C. Микобактерийн нөлөөгөөр уушгинд агуйт гэмтэл үүсэх
  - D. Арьсанд микобактер нэвчих
  - E. Тунгалгийн зангилаа тархмалаар гэмтэх
- /28./ Суурь мембраны коллагены гажгаас үүсдэг эмгэгийг сонгоно уу?
- A. Бергерийн өвчин
  - B. Гудпасчерийн хам шинж
  - C. Бодисын солилцооны хүчилшил
  - D. Люпус нефрит
  - E. Альпортын хам шинж
- /29./ Шүдлэг шугам гэж юу вэ?
- A. Цайвар болон улаан хүрэн өнгөт тромбын үенүүд
  - B. Чөмөгт ясны хугарлын үед үүсдэг олон тооны өөхөн дусал бүхий тосон эмболи
  - C. Ургийн шингэнд агуулагдах цус бүлэгнэлт идэвхжүүлэгч бүрэлдэхүүнүүд
  - D. Судасны хананд бэхлэгдэх тромбын хэсэг

- Е. Зүрхний хавхлага дээрх ургалт буюу тромбын хэлбэр
- /30./ Эдийн дамжлагын үе шатыг зөв дараалуулна уу?
- А. Бэхжүүлэлт – Блок цутгах – Нэвчүүлэлт – Зүсэх – Будах
  - В. Блок цутгах – Бэхжүүлэлт – Нэвчүүлэлт – Зүсэх – Будах
  - С. Блок бэлтгэх – Нэвчүүлэлт – Бэхжүүлэлт – Будах – Зүсэх
  - D. Нэвчүүлэлт – Блок цутгах – Нэвчүүлэлт – Зүсэх – Будах
  - Е. Бэхжүүлэлт – Нэвчүүлэлт – Блок цутгах – Зүсэх – Будах
- /31./ Фибринт үрэвслийн жишээг нэрлэнэ үү?
- А. Арьсан дээрх салхин цэцгийн цэврүү
  - В. Дууны хөвчний хаван
  - С. Арьсан дээрх бэлцрүү
  - D. Арьсан дээрх буглаа
  - Е. Дэлбэнгийн хатгааны саарал элэгжил
- /32./ Голомтлог ГН-ийн онцлогийг заана уу?
- А. Кресцент хэлбэрийн үржил явагдана
  - В. Гуд-Пасчерийн хам шинжийн үед тохиолдоно
  - С. Үрэвссэн түүдгийн нэг эсвэл хоёр хэлтэнцэрт өөрчлөлт илэрнэ.
  - D. Проксималь тахир сувганцрын эсүүдэд өөхөн дусал үүснэ
  - Е. Мөнгөлөх аргаар судлахад суурин мембран зузаарч “төмөр зам” мэт зураглал илэрнэ
- /33./ Аль эмгэгийн үед криптийн буглаа үүсдэг вэ?
- А. Бүдүүн гэдэсний шархлаат үрэвсэл
  - В. Кроны өвчин
  - С. Хиршпрунгийн өвчин
  - D. Мухар олгойн үрэвсэл
  - Е. Бүдүүн гэдэсний булчирхайлаг ургацаг
- /34./ Мембранжилт гломерулонефритийн үед электроны нягт тунадасжилт хаана тодорхойлогддог вэ?
- А. Суурь мембраны дотор
  - В. Эндотелийн доогуур
  - С. Подоцитийн хөлийн сэртэнгийн доогуур
  - D. Подоцитийн хөлийн хоорондуур
  - Е. Мезангийн матрикт
- /35./ Бамбай булчирхайн хавдрын аль хэлбэрийн үед “Өнчин Аннягийн нүдтэй” төстэй бөөстэй хавдрын эсүүд тодорхойлогддог вэ?
- А. Аденома
  - В. Фолликуляр карцинома
  - С. Тархилаг карцинома
  - D. Хөхлөг карцинома
  - Е. Анапластик карцинома
- /36./ Хавдар үүсгэгч ретровирусийг нэрлэнэ үү?
- А. Хүний Т эсийн лейкеми үүсгэгч вирус
  - В. Хүний папиллома вирус
  - С. Хепатит В вирус
  - D. Хепатит С вирус
  - Е. Эпштейн Барр вирус
- /37./ Аль хавдрын үед эсүүд нь шарсан өндөгтэй шинж үүсгэсэн микроскопид харагддаг вэ?
- А. Нейрофиброматоз
  - В. Ретинобластома
  - С. Эпендимома
  - D. Олигодендроглиома
  - Е. Менингиома
- /38./ Уушгины тромбоземболизм нь дийлэнхдээ хаанаас гаралтай байдаг вэ?
- А. Хөлийн гүнийн вен
  - В. Бугалгын артери

- C. Баруун зүрх
- D. Зүүн зүрх
- E. Хөхний өнгөц вен

/39./ Хүүхдийн хөх хам шинж аль гажгийн үед ажиглагддаг вэ?

- A. Фаллотын дөрвөл
- B. Тосгуур-ховдол хоорондын таславчийн гажиг
- C. Ховдол хоорондын таславчийн гажиг
- D. Тосгуур хоорондын таславчийн гажиг
- E. Артерийн битүүрээгүй цорго

/40./ Ямар эмгэгийн үед Рейдийн индексийг тооцоолдог вэ?

- A. Гуурсан хоолойн багтраа
- B. Гуурсан хоолойн архаг үрэвсэл
- C. Гуурсан хоолойн өмөн
- D. Завсрын хатгаа
- E. Дэлбэнгийн хатгаа

/41./ Ямар үхжилийн үед Лангхансын аварга эс тодорхойлогддог вэ?

- A. Бэрээт үхжил
- B. Тавт үхжил
- C. Ээдэмцэрт үхжил
- D. Өөхөн үхжил
- E. Ширхэглүүр төст үхжил

/42./ Мембранжилт гломерулонефриттэй ялган оношлох шаардлагатай люпус нефропатийн хэлбэрийг сонгоно уу?

- A. I төрөл
- B. II төрөл
- C. III төрөл
- D. IV төрөл
- E. V төрөл

/43./ Ямар хугацааны дараагаар үрэвслийн голомтонд макрофагууд давамгайлдаг вэ?

- A. 6-24 цаг
- B. 24-48 цаг
- C. 2-4 цаг
- D. Медиатороос хамаарч янз бүр
- E. Судасны нэвчилтийн механизмаас хамаарч янз бүр

/44./ Хемостазын хамгийн эхний шатанд гарах өөрчлөлтийг нэрлэнэ үү?

- A. Судасны агшил
- B. Тромбоцитын бөглөөс
- C. Эндотелийн үржил
- D. Цус бүлэгнэлтийн идэвхжил
- E. Фибринт бөглөөс

/45./ Бодисын солилцооны хүчилшлийг хэрхэн ангилдаг вэ?

- A. Анионы завсарт ба хэвийн анионы завсарт
- B. Давсний уусмалд хариу урвалтай ба тэсвэртэй
- C. Анхдагч хямрал ба ээнэгшлийн хариу үйлдэл
- D. Анхдагч ба хоёрдогч
- E. Бөөрний ба уушгины шалтгаант

/46./ Төмөр дутлын цус багадалтын үед түрхэцд ямар хэлбэрийн улаан эс үүсдэг вэ?

- A. Микроцит, гиперхром
- B. Микроцит, нормохром
- C. Микроцит, гипохром
- D. Макроцит, гипохром
- E. Макроцит, гиперхром

/47./ Цайвар цитоплазмтай тунгалаг "halo"-тай том эсүүд ямар өмөнгийн үед илэрдэг вэ?

- A. Педжетийн өвчин
- B. Хэлтэнгийн нэвчмэл өмөн

- C. Тархилаг өмөн
- D. Коллоид өмөн
- E. Цоргоны доторх батган өмөн

/48./ Цочмог үрэвслийн үед сийвэнгийн уураг болон шингэн хэсгүүд судаснаас гадагшлахад ямар шинж үүсдэг вэ?

- A. Халах
- B. Улайх
- C. Хавдах
- D. Өвдөх
- E. Үйл алдагдах

/49./ Уушгины тромбоэмболи нь ихэвчлэн хаанаас гаралтай байдаг вэ

- A. Хөлийн өнгөц вен
- B. Хөлийн гүнийн вен
- C. Дээд мөчдийн вен
- D. Гүрээний вен
- E. Элэгний вен

/50./ Идээт үрэвслийн хамгийн их нейтрофилтэй хэсгийг нэрлэнэ үү?

- A. А. Идээний бүс
- B. В. Нойтон үхжилт бүс
- C. С. Цусархаг бүс
- D. D. Идээний бүрхүүл
- E. E. Төлжлийн бүс

/51./ Маллорын биенцэр ямар эмгэгийн үед тохиолддог вэ?

- A. Архины шалтгаант элэгний өвчин
- B. Элэгний хатуурал
- C. Аутоиммун хепатит
- D. Вируст хепатит
- E. Төрөлхийн гипербилирубинем

/52./ Төмсөгний семинома нь өндгөвчний ямар хавдартай аналог вэ?

- A. Дисгерминома
- B. Шар уутны хавдар
- C. Өндгөвчний хориокарцинома
- D. Өндгөвчний тератома
- E. Өндгөвчний сертоли-лейдигийн эсийн хавдар

/53./ Хавдар хөндийт эрхтний хананы гүн рүү нэвчихийг ямар төрлийн ургалт гэдэг вэ?

- A. Хэсэг газрын нэвчмэл
- B. Экзофит
- C. Эндофит
- D. Түрэг ургалт
- E. Түлхэх ургалт

/54./ Меланиныг илрүүлэгч будгийг сонгоно уу?

- A. Перлсийн хөх
- B. Массоны фонтана
- C. Гримеп
- D. Родамин
- E. Рубеаны хүчил

/55./ Хүнцэл нь эсийн төвшинд хэрхэн үйлчилдэг вэ?

- A. Митохондрын ДНХ-ийг задлах
- B. Лизосомын мембраныг задлах
- C. Пероксисомын энзимүүд идэвхгүйжих
- D. бЭПТ-оос рибосомууд ховхрох
- E. Митохондрын исэлдэх форфоржуулах урвал саатах

/56./ Хоол боловсруулах замын хамгийн элбэг тохиолддог төрөлхийн эмгэгийг сонгоно уу?

- A. Мухар олгойн үрэвсэл
- B. Меккелийн цүлхэн

- C. Уруул тагнайн сэтэрхий
- D. Хиршпрунгийн өвчин
- E. Олон ургацагт хам шинж

/57./ Судсанд цус задралаас үүссэн гемоглобин хэрхэн биеэс ялгарах вэ?

- A. Цэсөөр
- B. Баасаар
- C. Шүлсээр
- D. Шээсээр
- E. Хөлсөөр

/58./ Хагеманы хүчин зүйлийн кофакторыг нэрлэнэ үү?

- A. Коллаген
- B. Суурь мембраны бүтэц
- C. Идэвхэжсэн тромбоцит
- D. Кининоген
- E. Идэвхэжсэн эндотели

/59./ Пролактиноматай холбоотой зөв ойлголтыг сонгоно уу?

1. Элбэг тохиолдоно
2. Үйл ажиллагаатай аденома
3. Харааны зөрлөгийг дарах эрсдэлтэй
4. Хавдар нь хүчиллэг эсүүдээс тогтоно
5. Хавдар нь мэдрэлийн дагуу үсэрхийлнэ

/60./ Өвчтөнөөс авсан эдийг гарлаар нь хэрхэн ангилах вэ?

1. Задлан шинжилгээний
2. Мэс засал эмчилгээний
3. Оношилгооны
4. Аналог загварын
5. Эсийн өсгөврийн

/61./ Барретын улаан хоолой өвчинтэй холбоотой зөв ойлголтыг сонгоно уу?

1. Улаан хоолойн доод 1/3 хэсгийн салст нь бортгон хучуур эдээр солигдоно
2. Бортгон эсүүдийн бөөмийн томрол болон хэт будагдалт бүхий дисплази илэрнэ
3. Бортгон эсүүдийн дунд хундган эсүүд харагдана
4. Хавтгай эст өмөнгийн эрсдэл нэмэгдэнэ
5. Рентгенд хархны сүүлний шинж илэрнэ

/62./ Давсны уусмалд хариу урвалтай бодисын солилцооны шүлтшлийн шалтгааныг нэрлэнэ үү?

1. Бөөлжилт
2. Шээс хөөх эм
3. CO<sub>2</sub>-ын хэт ихсэл
4. Конны хам шинж
5. Кушингийн өвчин

/63./ Хэрэхийн цочмог чичрэгтэй холбоотой зөв ойлголтыг сонгоно уу?

1. А бүлгийн β цус задлагч Streptococcus-ийн халдвараар үүсгэгдэнэ.
2. Өвчтөний өөрийн эдтэй солбилцох урвалд өрнөнө
3. Зүрхний бүх ханыг хамарсан үрэвсэл өрнөнө
4. Ихэвчлэн 5-15 насныхан өвчилнө
5. Зүрхний хэрэх өвчин үүсгэж хүндэрнэ

/64./ Цочмог үрэвслийн шалтгааныг нэрлэнэ үү?

1. Халдвар
2. Гэмтэл
3. Химийн хүчин зүйл
4. Физикийн хүчин зүйл
5. Эдийн үхжил

/65./ Трансудант буюу хавангийн шингэн үүсэхэд хүргэдэг хүчин зүйлийг нэрлэнэ үү?

1. Судсан дахь шингэний эзэлхүүн ихсэх
2. Сийвэнгийн уураг багасах

3. Судсан дахь гидростатик даралт ихсэх
  4. Сийвэнгийн уураг ихсэх
  5. Сийвэнгийн давс ихсэх
- /66./ Олон зангилаат бахууны үед ямар эмгэг өөрчлөлт бий болдог вэ?
1. Бамбай тэгш бус томрох
  2. Бамбай булчирхайд зангилаанууд хэлбэржинэ
  3. Шохойжлын голомт
  4. Сорвижлын голомт
  5. Коллоидын үгүйрэл
- /67./ Нойтон илжрэл үүсгэгчдийг нэрлэнэ үү?
1. Clostridium perfringens
  2. Bacillus fusiformis
  3. Bacillus histolyticus
  4. Proteus mirabilis
  5. Mycobacterium tuberculosis
- /68./ Архины хепатитийн үед микроскопид ямар өөрчлөлт илэрдэг вэ?
1. Хепатоцитүүд хөөмөгшсөн эсвэл үхжсэн
  2. Маллорын биенцэр
  3. Нейтрофилийн нэвчдэс
  4. Хадаасны шинж
  5. Бүгээн шилний шинж
- /69./ Архаг үрэвслийн шалтгаант анемид хүргэх өвчнүүдийг сонгоно уу?
1. Тогтолцооны архаг өвчин
  2. Архаг халдварт өвчин
  3. Хавдар
  4. Ревматоид артрит
  5. Вирусийн халдвар
- /70./ Тромболизм үүсгэх урьдчилсан нөхцлийг заана уу?
1. Цусны урсгалын зогсонгошил
  2. Хэт бүлэгнэлтийн байдал
  3. Судасны ханын гэмтэл
  4. Тромбоцитын цөөрөл
  5. Цус бүлэгнэлтийн факторуудын дутагдал
- /71./ Азотын исэл/оксидийн онцлогийг нэрлэнэ үү?
1. Хийн төлөвтэй
  2. Уусамтгай шинж чанартай
  3. Эс хордуулагч үүрэгтэй
  4. Нейротрансммиттерийг зохицуулах
  5. Амархан задардаг
- /72./ Тохирсон тун бүхий архины ач холбогдлыг нэрлэнэ үү?
1. Тромбоцитын наалдалтыг бууруулах
  2. Их нягтралтай липопротеин ихсэх
  3. Фибриногений хэмжээг багасгах
  4. Титэм судасны өвчнөөс сэргийлэх
  5. Бага нягтралтай липопротеиныг ихэсгэх
- /73./ Төмсөгний хөврөл эсийн хавдрын аль хэлбэрийн үед сийвэнгийн hCG ихэсдэг вэ?
1. семинома
  2. Үр хөврөлийн карцинома
  3. Тератома
  4. Хориокарцинома
  5. Эндодермийн хөндийн хавдар
- /74./ Уушгины архаг хязгаарлалт өвчний үр дагаврыг сонгоно уу?
1. Сорвижлоор намжих
  2. Завсрын эдийн давшингуй сорвижил
  3. Зөгийн үүр хэлбэржих

4. Уушгины дарал ихдэл
  5. Уушги-зүрхний хам шинж
- /75./ Цэсний хүүдийн аденокарциноматай холбоотой зөв ойлголтыг заана уу?
1. Цэсний хүүдийн хана нилэнхүйдээ зузаарах
  2. Хавдар хананаас товойж цэцэгт байцаа мэт ургах
  3. Голчлон элэг рүү үсэрхийлэх
  4. Хавдрын эсүүд салс ялгаруулах
  5. Дэвсгэр эдийн сорвижил
- /76./ Атеросклерозын үед ямар судсанд эмгэг өөрчлөлт үүсдэг вэ?
1. Том уян артери
  2. Том булчинлаг артери
  3. Дунд зэргийн голчтой булчинлаг артери
  4. Жижиг булчинлаг артери
  5. Хялгасан судас
- /77./ Панкоаст хавдартай холбоотой зөв ойлголтыг сонгоно уу?
1. Зовхи унжих
  2. Хүүхэн хараа нарийсах
  3. Хөлсгүй болох
  4. Хүзүүний лимфатик сүлжээ гэмтэх
  5. Хавдрын цул уушгины суурь хэсэгт оршино
- /78./ Нарны хэт ягаан туяа нь ямар хавдрын эрсдэл болдог вэ?
1. Меланома
  2. Арьсны хавтгай эс өмөн
  3. Суурь эсийн өмөн
  4. Архаг лимфоид лейкеми
  5. Архаг миелоид лейкеми
- /79./ Кроны өвчний үед илэрдэг гэдэсний бус шинжүүдийг заана уу?
1. Амны хөндийн үлхийн шархлаа
  2. Арьсны зангилаат улайрал
  3. Олон үений шилжмэл үрэвсэл
  4. Нүдний судаслаг үрэвсэл
  5. Нурууны үений барьцалдаат үрэвсэл
- /80./ Зүүнээс баруунд чиглэлтэй шунт аль гажгуудын үед ажиглагддаг вэ?
1. Ховдол хоорондын таславчийн гажиг
  2. Тосгуур хоорондын таславчийн гажиг
  3. Тосгуур-ховдлын таславчийн гажиг
  4. Артерийн битүүрээгүй цорго
  5. Уушгины судаснаас титэм судасны зүүн салаа гардаг гажиг
- /81./ Дараахаас аль тохиолдолд шигдээс үүсэх вэ?
1. Цус зогсонгошил
  2. Ивэрхий хавчигдах
  3. Хавдар түрж ургах
  4. Гэдэс чихэгдэх
  5. Өндгөвч мушгирах
- /82./ Үхжилийн таатай төгсгөлийг сонгоно уу?
1. Шохойжих
  2. Сорвижих
  3. Уйланхайжих
  4. Шимэгдэх
  5. Ясжих
- /83./ Нейтрофил ихээр задарч захын цусны нейтропенид хүргэх шалтгаануудыг нэрлэнэ үү.
1. Их хэмжээний халдвар
  2. Хор
  3. Эмийн бодис

4. Аутиммун урвал
  5. Хиперспленизм
- /84./ Архаг үрэвслийн ерөнхий шинжийг нэрлэнэ үү?
1. Ангиогенез
  2. Мононуклеар эсийн нэвчдэс
  3. Сорвижил
  4. Их хэмжээний үрэвслийн шингэн
  5. Олон тооны нейтрофилийн нэвчдэс
- /85./ Хөхний хэлтэнгийн нэвчмэл өмөнгийн үед ямар эмгэг өөрчлөлт илэрдэг вэ?
1. 2 хөхөнд, олон тооны голомттой ургана
  2. Хавдрын эсүүдийн эгнээ нь "индианы цуваа" үүсгэнэ
  3. Заримдаа бөгжин эсүүд харагдана
  4. Хэлтэнгийн байран өмөнгөөс үүснэ
  5. Хавдар цийдмэг тогтоцтой
- /86./ Краниофарингиомын эмгэг бүтэцтэй холбоотой зөв хариуг сонгоно уу?
1. Кератин хэлбэржсэн
  2. Уйланхай үүссэн
  3. Шохойжлын голомттой
  4. Давхраат хавтгай хучуур эсээс тогтоно
  5. Бортогон хучуур эдийн хөвчүүд агуулагдана
- /87./ Хүүхдийн бөөрний олон уйланхайт өвчинтэй холбоотой зөв ойлголтыг сонгоно уу?
1. Уйланхайнууд нь нэгэн жигд хэмжээтэй
  2. Уйланхайнууд нь битүү, жижиг хэмжээтэй
  3. Бөөрний гадаргуу хэвийн
  4. Аутосом доминантаар удамшина
  5. Өвчтөн ихэвчлэн эхний 2 жилийн дотор эндэнэ
- /88./ Тархины судасны атеросклерозын үр дагаврыг сонгоно уу?
1. Цочмогоор бөглөрч шигдээс
  2. Судас хагарч цус харвалт
  3. Тархины архаг цус хомсрол
  4. Оюуны үйлийн доройтол
  5. Ухаан алдах
- /89./ Нүүрстөрөгчийн дутуу ислийн онцлогийг тодорхойлно уу?
1. Үнэргүй
  2. Амтгүй
  3. Өнгөгүй
  4. Хемоглобинтой холбогдох өндөр авцаал чадвартай
  5. Улаан эсийн мембрантай тогтвортой нэгдэл үүсгэдэг
- /90./ К аминдэмийн дутагдлын шалтгааныг заана уу?
1. Элэгний өвчин
  2. Хоол шингээлтийн алдагдал
  3. Варфарины хэрэглээ
  4. Аутосом рецессив удамшил
  5. Х-хромосомын рецессив удамшил
- /91./ Саркоидозын үед илрэх бичил бүтцийн өөрчлөлтийг нэрлэнэ үү?
1. Төвдөө сорвижилтой мөхлөгөнцөр
  2. Мөхлөгөнцрийг эпителиод, Лангхансын эсүүд хүрээлнэ
  3. Одлог биенцэр
  4. Schaumann-ын биенцэр
  5. Мөхлөгөнцөр нь төвдөө ээдэмцэрт үхжил агуулна
- /92./ Судасны ханын бүрэн бүтэн байдал алдагдахад юуны өмнө судас агшдаг. УЧИР НЬ гэмтсэн эндотелийн цитоскелет ялгарна.

/93./ Сүрьеэгийн үед цустай цэртэй ханиалгах шинж илэрдэг. УЧИР нь уушгинд агуйт гэмтэл үүсч, цусны судас гэмтсэнтэй холбоотой.

/94./ Шээс хоригч дааврын хэмжээ ихсэхэд сийвэнгийн натрийн хэмжээ ихэсдэг. УЧРААС давс усыг татах механизмаар эдийн шингэн сийвэн рүү шилждэг.

/95./ Тэмбүүгийн шалтгаант гол судасны цүлхэн нь гол судасны хавхлаганы үйлийг алдагдуулдаг. УЧИР нь энэ үед модны насжилтын цагаригийн шинж үүсдэг.

/96./ Удамшлын сфероцитоз нь мембранопатийн нэг төлөөлөгч эмгэг УЧИР нь спектрин, ангириин зэрэг мембран уургийн аутосом гажигийн улмаас үүсдэг.

/97./ Ээдэмцэрт үхжил үүсэхэд эд хуурай цайвар харагддаг. УЧИР нь уг үхжилийн хэлбэр нь энзимийн идэвхжил ихтэй, ихээхэн шингэн бүхий эдэд тохиолддог онцлогтой.

/98./ Нойр булчирхайн эмгэгүүдийн үед амилаза, липаза зэрэг энзимүүд сийвэн рүү чөлөөлөгддөг. УЧРААС липаза нь нойр булчирхайн үрэвслийн үед илүү өвөрмөц юм.

/99./ Бага эргэлтийн даралт ихсэхэд зүрхний гажгийн эс үүсдэг. УЧИР нь хэт их даралтын нөлөөгөөр уушгины хялгасан судаснуудаас цулцангийн хөндий рүү улаан эсүүд шүүрдэг.

/100./ Лейомиома нь хамгийн элбэг тохиолддог. УЧИР нь энэ нь хромосомын гажигтай холбоотой.

## **Сорилын зөв хариулт-Жишиг сорил-2**

1-B, 2-A, 3-A, 4-A, 5-E, 6-E, 7-B, 8-A, 9-E, 10-D, 11-C, 12-E, 13-E, 14-B, 15-A, 16-A, 17-A, 18-D, 19-E, 20-C, 21-C, 22-E, 23-D, 24-C, 25-B, 26-A, 27-B, 28-E, 29-A, 30-E, 31-E, 32-C, 33-A, 34-C, 35-D, 36-A, 37-D, 38-A, 39-A, 40-B, 41-C, 42-E, 43-B, 44-A, 45-B, 46-C, 47-A, 48-C, 49-B, 50-A, 51-A, 52-A, 53-C, 54-B, 55-E, 56-B, 57-D, 58-D, 59-A, 60-A, 61-A, 62-A, 63-E, 64-E, 65-A, 66-B, 67-B, 68-A, 69-B, 70-A, 71-E, 72-B, 73-B, 74-E, 75-A, 76-E, 77-B, 78-A, 79-E, 80-E, 81-E, 82-C, 83-A, 84-A, 85-B, 86-E, 87-A, 88-E, 89-E, 90-A, 91-B, 92-C, 93-A, 94-E, 95-B, 96-A, 97-E, 98-A, 99-A, 100-A,

## **Жишиг сорил-3**

### **Тохиолдол 1**

47 настай эрэгтэй гастродуоденоскопи шинжилгээг хийж ходоодны салтсаас эд авч гистологи шинжилгээнд илгээв. Эд эсийн шинжилгээний хариу: “Ходоодны архаг шархлаа сэдрэлтийн үедээ” гэсэн онош тавьсан байна.

#### **1. Ходоодны архаг шархлааг яагаад “пепсиний” гэж нэрлэдэг вэ?**

- A. Ходоод дээд гэдэснээс өөр газар үүсдэггүй учир
- B. Ходоодны хүчил агуулсан шүүс (пепсиноген)-ий зохицууллагын алдагдлаас **B**
- C. Ходоодны хүчил агуулсан шүүс (пепсиноген)-ий ихсэлттэй холбоотой
- D. Ходоодны хүчил ихсэхэд үүсдэг учраас
- E. Дээд гэдэсний шүүрэл ходоодны гарах хэсэгт сөргөж ордог учраас

#### **2. Пепсиний шархлааны зонхилон байрлах газруудыг нэрлэнэ үү?**

- 1. Их бие, нугалуур хэсэг
- 2. Дээд гэдэсний эхэн хэсэг

3. Ходоодны ёроол хэсэг **С**

4. Бага махиа, нугалуур хэсэг

5. Их бие болон гарах хэсэг

3. **Архаг шархлааны сэдрэлтийн үеийн өөрчлөлтүүд нь аль вэ?**

1. Ширхэглүүрт үхжил

2. Лейкоцит эсийн нэвчдэс

3. Мөхөлгөнцөрт эдийн ургалт **В**

4. Эндоартерит

5. Холбох эдэн сорив

4. **Архаг шархлааны намжилтын үед ямар үйл явц ажиглагдах вэ?**

1. Лейкоцит эсийн нэвчдэс багасах

2. Мөхөлгөнцөрт эд ихээр бий болох

3. Хатуу соривт эд их байна **А**

4. Холбох эдийн салсархаг хөөлт

5. Ширхэглүүрт үхжил ихтэй

5. **Ходоодны архаг шархлаанаас цочмог шархлаа нь дараах шинжүүдээр ялгагдана.**

1. Салс ба салстын доод давхар үхжинэ.

2. Голдуу олон тоотой байдаг.

3. Ходоодны аль ч хэсэгт тохиолдож болно. **А**

4. Шархлааны ирмэг дээш өргөгдсөн

5. Шархны хана нь шаталсан байна

## Тохиолдол 2

Өвчтөн Я. 56 настай, эмэгтэй. ЭХО-д цөсөндөө чулуутай онош тогтоогдож байсан. Өндөр халуурч, арьс шарлан, баруун хавирганы нумаар унжин өвдөлт ихтэй эмнэлгт хэвтсэн. ЭХО-д цөсний хүүдий дүүрэн чулуутай, элэгний архаг үрэвсэл, нойр булчирхайн толгой том. Хагалгаанд орж цөсний хүүдийг авахуулсан. Мэс заслын биопсийн материалын хариу: Эмгэг судлал (патогистологийн) онош: Цөсний хүүдийн шархлаат идээт үрэвсэл.

1. **Цөсний хүүдийн эд эсийн шинжилгээний өөрчлөлтүүд нь юу вэ?**

1. Хучуур эсүүдийн гуужилт

2. Салст дахь шүүдэс нь идээтэй

3. Бичил судсуудын өргөсөл, зогсонгошил **Е**

4. Үрэвслийн нэвчдэстэй

5. Салстын хөөлт, хавагналт

2. **Механик шарлалтын шалтгаан юу вэ?**

А. Цөсний хүүдийн чулуу

В. Цөсний ерөнхий цоргын чулуу

С. Нойр булчирхайн толгойн хавдар **С**

Д. Фатеров хөхлөгийн хавдар

Е. Дээд гэдэсний хавдар

3. **Цөс зогсонгошлийн гепатитын үед элэгний эдэд гарах бичил өөрчлөлтүүдээс нэрлэнэ үү?**

1. Элэгний эдэд цөсний нуур үүсэх

2. Элэгний эсийн сийвэнд бор мөхлөгүүд байна

3. Элэгний эсүүдийн үхжил, синусоидын урвал ихтэй **В**

4. Цөсний цорго тойрсон лимфоид үржил их

5. Гепатоцит эсийн сийвэнд өөхөн дусал бий болох

**4. Цөсний хүүдийд ямар үрэвсэл үүссэн вэ?**

1. Архаг холецистит сэдэрч идээт үрэвсэл өрнөсөн
2. Идээт шархлаат үрэвсэл үүссэн
3. Анхдагчаар шархлаат холецистит үүссэн
4. Хоёрдогчоор идээт шархлаат үрэвсэл үүссэн
5. Хоёрдогчоор шархлаат холецистит үүссэн

**A**

**5. Элгэн доорхи шарлалтын шалтгаан юу байдаг вэ?**

1. Элэгний хавдар цоргыг дарах
2. Цөсний чулуужих өвчин
3. Цөсний цоргын аденома
4. Нойр булчирхайн толгойн хавдар
5. Цөсний ерөнхий цоргын үрэвсэл

**E**

**Тохиолдол 3**

Өвчтөн 39 настай эрэгтэй баруун хавирганы нумаар өвдөнө, арьс шарласан, хоолонд дургүй, халуурна гэсэн зовиуртай. Амьдралын түүхээс урьд нь шарласан. Эмнэлзүй болон бүрдэл шинжилгээнүүдийг үндэслэн өвчтөнөөс элэгний биопси авч эд эсийн шинжилгээнд илгээв. Эд эсийн шинжилгээний дүгнэлт “Архаг идэвхит вирусын шалтгаант элэгний үрэвсэл” гэжээ.

**1. Элэгний эдээс биопси материалыг ямар аргаар авах вэ?**

- A. Соруулж
- B. Хатгаж
- C. Дурангаар
- D. Зүсэж
- E. Сэтгүүрдэж

**B**

**2. Архаг идэвхит вируст гепатитын үед элгэнд гарах макро өөрчлөлт аль нь вэ?**

1. Элэгний хэмжээ хэвийн, гадаргуу гөлгөр
2. Хүрэн улаан өнгөтэй, томорсон элэг
3. Элэгний ирмэг хурц, гадаргуу хатуувтар
4. Элэгний хальс бүрхүүл чинэрсэн
5. Элэг зөөлөрч улбагар, цайвар шар өнгөтэй

**C**

**3. Бичил шинжилгээгээр архаг идэвхит гепатитын үед доорхи өөрчлөлтүүдээс аль нь илрэх вэ?**

1. Элэгний хэлтэнцэрт гүүр маягийн үхжил үүснэ
2. “Сүүн шилэн эс” шинж бүхий эсүүд олон
3. Үрэвслийн урвал хаалган зурвасаас халина
4. Цөсний зогсонгошил, өөхөн хувиралуудтай болсон
5. Элэгний эдийн хэлтэнцэрт бүтэц алдагдана

**E**

**4. Архаг гепатит идэвхжихэд элэгний эдэд ямар эс харагдах вэ?**

1. Маллорийн биенцэр
2. Лангхансын эс
3. Штернбергийн эс
4. Каунсильменин биенцэр
5. Хөөсөрхөг эс

**D**

**5. Архаг гепатитийн гистологи шинжилгээний “Сүүн шилэн эс” гэж ямар эсийг хэлэх вэ?**

1. Апоптозд орж байгаа элэгний эс
2. Эсийн сийвэн гиалин маягийн өөрчлөлтөнд орсон эс
3. Задарч байгаа элэгний эс
4. HbsAg-ийн хүчилсэг тундас агуулсан эс
5. Гэмтсэн Купферийн эс

Д

**6. Архаг идэвхит гепатитын үед элэгний эдэд үрэвслийн ямар эсүүд гарах вэ?**

1. Лимфоцит
2. Гистоцит
3. Хэлтэнцэрийн гүн рүү нэвтэрсэн
4. Гүүрэн үхжил давамгайлна
5. Хаалган зурвасын дагуу

В

**Тохиолдол 4**

Өвчтөн Р. Б 63 настай, эрэгтэй. Тамхи их татдаг. Олон жилийн өмнөөс даралт ихдэл өвчнөөр өвчилж байсан ба сүүлийн 2 жилээс зүрхээр өвддөг болсон. 7 хонгийн өмнөөс даралт ихдэж зүрхээр өвдөөд эмнэлэгт хандсан. Шинжилгээгээр:

Эмнэлзүйн онош: Зүрхний цочмог шигдээс,

Эмгэг судлалын онош: Зүрхний цочмог шигдээс, түүний хүндрэлүүдийн улмаас олон эрхтэний дутагдлаар нас барсан.

**1. Зүрхний шок үүсгэгч гол эмгэгийг заана уу?**

- A. Зүрхний хэт томрол
- B. Зүрхний өөхлөлт
- C. Зүрхний шигдээс
- D. Зүрхний хатуурал
- C. Зүрхний митрал хавхлагын нарийсал

С

**2. Атеросклерозийн эхэн шатанд судасны дотор давхарт гарах гол өөрчлөлтийг нэрлэнэ үү?**

- A. Өөх хуримтлал
- B. Уян ширхэгийн тасрал
- C. Кальцийн хуримтлал /шохойжил/
- D. Нүхний нарийсал
- E. Тромб үүсэл

А

**3. Судасны хананд өөх шингээгч ямар төрлийн эс байх вэ?**

- A. Фибробласт эсүүд
- B. Эндотелийн эс
- C. Лимфоцит эс
- D. Эпителийн эс
- E. Гөлгөр булчингийн эсийн

Е

**4. Атеромын товруу үүсэх боломж илүүтэй судаснуудыг заана уу?**

1. Гүрээний артери
2. Чацархайн дээд , доод артери
3. Гол судасны хэвлийн хэсэг
4. Зүрхний титэм артери
5. Бөөрний артери

В

**5. Судас хатуурах өвчний өөхлөлтийн үед бичил шинжилгээгээр судасны хананд гарах өөрчлөлтүүд аль нь вэ?**

1. Гөлгөр булчингийн эсүүд үржин олширно
2. Уян ширхэг хөөж хавагнана
3. Холбох эдийн залуу эсүүд бий болно
4. Хөөсөрхөг(ксантома) эсүүд үүсдэг
5. Судасны эндотелийн эсүүд үржинэ

**С**

## **Тохиолдол 5**

Өвчтөн 62 настай А. Д. Сүүлийн үед ядарч сульдана. Даралт ихсэж зүрхээр өвдөнө. Шээсний гарц зовиуртай болсон. Бага зэрэг турсан гэсэн өгүүлэлтэй эмчид ирсэн. Үзлэгт түрүү булчирхайн тэмтрэлтээр зөөлөн гадаргуу гөлгөр. Шинжилгээ: ЭХО-д булчирхайн хэмжээ 6x5.4x6.2 см эхо ойлт жигд, цусанд PSA 5.7 үндэслэн түрүү булчирхайн эмгэгүүд гэж үзэж байгаа бол

### **1. Дараах эмгэгүүдээс аль нь дээрх өвчний оношид тохирох вэ?**

- A. Түрүү булчирхайн хортой хавдар
- B. Түрүү булчирхайн томрол
- C. Түрүү булчирхайн үрэвсэл
- D. Орхиоэпидедимит
- E. Крипторхизм

### **Зөв хариу - B**

### **2. Түрүү булчирхайн жирийн томрол /гиперплази/ макро өөрчлөлтүүдээс нэрлэнэ үү?**

1. Түрүү булчирхайн нийт жин 75 гр
2. Зангилаанууд нь шээлүүрийн гадуур тойрч ургасан
3. Булчирхайлаг бүтэц нь бүрхүүлийг эвдэн эд рүү нэвчиж ургасан **A**
4. Зүслэгээр орчныхоо эдийг дарж ургасан
5. Зангилаануудаар дарагдсан шээлүүрийн нүх хавчийж нарийссан

### **3. Түрүү булчирхайн жирийн томролын микро өөрчлөлтийг нэрлэнэ үү?**

1. Булчирхайн хөхлөг маягийн ургалт
2. Булчирхайн уйланхайт хөндийнүүд үүсэх
3. Булчин ба холбох эдийн үржил **E**
4. Хатингаршсан булчирхайнууд бий болох
5. Хуурамч бүрхүүл үүсч хучих

### **4. Түрүү булчирхайн томролын хүндрэлээс нэрлэнэ үү?**

1. Шээсний архаг хаагдал
2. Цистит, пиелонефрит
3. Бөөр усжих **E**
4. Давсагны ээнэгшилт томрол
5. Давсагны чулуу, дивертикул